

“ШИВЭЭ ОВОО” ХК 2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь тухайн төслийн байгаль орчинд учруулж буй гол нөлөөлөл болон болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээг тодорхойлж, тухайн жилд түүнд шаардагдах хөрөнгө зардлыг баталгаатай байлгах үндэслэл болно. Төсөл хэрэгжүүлэгч нь тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг 11 дүгээр сарын 01-ний дотор аймгийн байгаль орчны газарт хүргүүлнэ.

2022 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг хүлээж авсан аймгийн Байгаль орчны газар түүний биелэлтийг шалгаж, дүгнэлт гаргах ажлын хэсгийг аймгийн Засаг даргын захирамжаар байгуулж, ажилуулан дүгнэлтийг 12 дугаар сарын 1-ний дотор гаргуулна. Тус ажлын хэсэгт аймгийн ЗДТГ-ын Хөгжлийн бодлогын хэлтэс, Байгаль орчны газар, Мэргэжлийн хяналтын газар, Сав газрын захиргаа, сумын ЗДТГ-ын төлөөлөл, Байгаль орчны хяналтын улсын байцаагч, Байгаль хамгаалагч, Газрын даамал орно.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийг ажлын хэсгийн гишүүд газар дээр нь очиж шалган 0-100% хүртэл оноогоор дүгнэх ба 90%-иас дээш байвал биелэлтийг хангалттай гэж үзнэ.

Ашигт малтмалын орд ашиглаж буй төсөл хэрэгжүүлэгч уул уурхайн олборлолтын улмаас эвдэрсэн газрын нөхөн сэргээлтийн тухайн жилийн мэдээг БОХ-3 маягтын дагуу гаргаж тухайн сум, дүүргийн ЗДТГ-т жил бүрийн 12 дүгээр сарын 25-ны дотор хүргүүлэх ба байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд заавал хавсаргана.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайлан, түүнд хийсэн ажлын хэсгийн дүгнэлтийг үндэслэн, биелэлтийг хянаж, дараагийн жилд хэрэгжүүлэх байгаль орчны менежментийн төлөвлөгөөг батална.

Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг жил бүрийн 03 -р сарын 25-ны дотор БОАЖНХЯаманд боловсруулж хүргүүлэн баталгаажуулна

Оршил

БНМАУ-ын Сайд нарын зөвлөлийн 1989 оны 4-р сарын 26-ний өдрийн 98 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх арга хэмжээний хүрээнд 1989 оны 5-р сарын 24-ний өдөр ЭХУУҮГЯамны сайдын 134 дүгээр тушаал гарч Шивээговь хотхоны хамгаалалт, ашиглалтын түр захиргаа байгуулахаар шийдвэрлэсэн нь өнөөдрийн Шивээ Овоогийн нүүрсний уурхайн үндэс суурь болжээ.

Жилдээ 500.0 мян.тн нүүрс олборлон борлуулах хүчин чадалтай уурхай байхаар анхны зураг төсөл нь батлагдаж улмаар уурхайн амыг 1990 оны 07-р сарын 31-ний өдөр нээж, 1991 оны 12-р сарын 23-ны өдөр анх нүүрсээ олборлож эхэлжээ. 1993 онд техникийн шинэчилэл хийгдэж төслийн хүчин чадлаа эзэмшсэн.

Монгол улсын Засгийн газраас тус уурхайг хувьчлах шийдвэр гаргаж, улмаар 1995 оны 09-р сарын 12-ны өдөр “Шивээ Овоо ХК”-ийг байгуулсан. Нийт дүрмийн сангийн 90%-ийг төр, 10%-ийг хувь нийлүүлэгчид эзэмшдэг тус компанид Нүүрсний салбарыг хөгжүүлэх “Мастер төлөвлөгөө”-ний хүрээнд 1998 онд Япон улсын Засгийн газрын хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр уурхайн техник, технологийг шинэчлэх төсөл хэрэгжиж эхэлсэн.

Шивээ Овоогийн уурхай нь жилдээ 8.6 сая.м3 хөрс хуулж, 2.0 сая.тн нүүрс олборлон, борлуулах хүчин чадалтай болсон байна. 2019 оны 01-р сарын 09-ний өдрийн ЭБМЗ-ийн хурлаар, улсын төвийн эрчим хүч, дулааны хэрэглээний өсөлтийг үндэслэн 4.5 сая тн нүүрс олборлох ТЭЗҮ-г хэлэлцүүлж 2019 оны 5-р сарын 13-ны өдөр батлагдсан. Шивээ Овоогийн ордын нүүрс нь Х-3 бүлгийн хүрэн нүүрсний ангилалд хамаарах ба одоогийн байдлаар Монгол улсын дотоодын нүүрсний хэрэгцээний 28.3%, “ДЦС-4” ТӨХК-ийн хэрэгцээний 50.0%-ийг дангаараа хангаж байна.

Жилд дунджаар Улсын төсөвт Говьсүмбэр аймгаас оруулж байгаа нийт төвлөрсөн төсвийн орлогын 83.7% буюу 4,4 тэрбум төгрөг, орон нутгийн төсвийн орлогын 61.0% буюу 1.55 тэрбум төгрөг, аймгийн нийт төсвийн орлогын 75.5%-ийг “Шивээ Овоо” ХК дангаараа бүрдүүлж байна.

Уурхай нь 2022 оны 12-р сарын 31-ний байдлаар 38.8 сая.тн нүүрс олборлон, 35.5 сая.тн нүүрс хэрэглэгчдэд нийлүүлэн, 37.4 сая.м3 тээвэргүй хөрс хуулалт, 100.2 сая.м3 тээвэртэй хөрс хуулалт, 35.9 сая.м3 дахин шидэлт, 11.4 сая.м3 инженер ажил хийж нийт 216.9 сая.м3 уулын цулын ажил гүйцэтгээд байна.

2020 онд JBIC-ийн зээлийн хүрээнд хийгдсэн технологийн автомашин, гидроэкскаваторын шинэчлэлийн хүрээнд техникийн найдвартай ажиллагаа тогтворжсон.

Уурхайн гүн 114 гаруй метрт хүрч хөрс хуулалтын ажил нэмэгдэж мөн 2011 оноос хойш хөрсний хоцрогдол үүссэн талбайд тээвэртэй хөрсний доголдууд ахиулж ЭШ 25/90 алхагч экскаваторын ажиллах фронтыг бэлтгэх болсонтой холбогдуулан хөрс тээвэрлэлтийн талын

зайг ойртуулах 2018-2019 онуудад олборлолт хийгдээгүй талбайд илэрсэн хагарал суулт, дотоод овоолгын гулсалтыг удирдах ажлын хүрээнд хийгдсэн тулгуур цликийн нүүрсийг олборлож, цликийг шилжүүлж үлдээх, ашиглалтын 1-р амны баруун жигүүрийн гарш талд нарийн орлоор тээвэртэй хөрс хуулж хөрс хуулалтын хоцрогдлыг бууруулж ажиллах зэрэг онцлогуудыг төлөвлөгөөнд тусган боловсруулсан.

1. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Шивээ Овоогийн уурхайн газар зүйн товч тодорхойлолт

Шивээ Овоогийн орд нь Говьсүмбэр аймгийн Шивээговь сумын нутагт, аймгийн төв Чойр хотоос зүүн урагш 20 км, Улаанбаатараас зүүн урд зүгт 260 км зайнд оршдог.

Тус ордод Төвийн геологийн экспедици 1986-1988 онуудад урьдчилсан ба нарийвчилсан хайгуул хийсэн байна. Шинэ-Усны хэсгийн хил нь баруун талаараа Чойр-Сайншандын төмөр зам, зүүн талаараа нүүрсний I давхаргын гарш, өмнөд талаараа хайгуулын 3-р хөндлөн шугамаар хязгаарлагддаг. Гадаргуу нь дов толгодорхог, далайн түвшнээс дээш 1180-1230 м өргөгдсөн бөгөөд дов толгодыг элсэн чулуу, бялхмал ба гүний чулуулгуудын илэрцүүд үүсгэдэг.

Ордын нийт нөөц 2,7 тэрбум тонн, үүнээс 665,4 сая тонн нийт нөөцийг 1988 онд гүйцэтгэсэн нарийвчилсан хайгуулын ажлаар Шинэ-Усны хэсэгт тогтоосон байдаг. Өнөөдрийн байдлаар стратегийн ач холбогдол бүхий Шивээ Овоогийн хүрэн нүүрсний ордын тусгай зөвшөөрлүүдийг дараах 3 хуулийн этгээд эзэмшиж байна (Хүснэгтээс харах).

Стратегийн ач холбогдол бүхий Шивээ Овоогийн хүрэн нүүрсний ордын тусгай зөвшөөрөл эзэмшигчид

Хүснэгт-№1

д/д	Тусгай зөвшөөрлийн эзэмшил	Тусгай зөвшөөрөл бүхий талбайн нэр	Тусгай зөвшөөрлийн дугаар	Тусгай зөвшөөрлийн талбайн хэмжээ/га
1	“ШИВЭЭ ОВОО” ХК	Шивээ Овоо	901А	91
2	"ЭРДЭНЭС МОНГОЛ" ХХК	Талбай-1	13311А	2784.0
3	"ЭРДЭНЭС МОНГОЛ" ХХК	Талбай-2	13312А	1239
4	"ЭРДЭНЭС МОНГОЛ" ХХК	Талбай-3	13313А	270
5	“ЭЙКҮСОРА” ХХК	Шивээговь-1	8294Х	7115
6	“ЭЙКҮСОРА” ХХК	Хүрэн дух	8296Х	22373
7	“ЭЙКҮСОРА” ХХК	Шивээговь	8297Х	596.09
8	“ЭЙКҮСОРА” ХХК	Шивээ-2	8829Х	737
9	“ЭЙКҮСОРА” ХХК	Шивээ-1	8830Х	501
10	“ЭЙКҮСОРА” ХХК	Шивээ-2	13250Х	691
11	“ЭЙКҮСОРА” ХХК	Шивээ-1	13251Х	468


1990 оны 7-р сарын 31-ний өдөр Шивээ Овоогийн уурхайн ашиглалтын ам нээж ашиглалтанд оруулсанаар түүхийн үе эхэлдэг. 1991 оны 12-р сарын 23-ны өдөр анхны нүүрсээ олборлож, 1995 оны 9-р сарын 22-нд “Шивээ Овоо” ХК болж өргөжжээ. Нийт хувьцааны 90%-ийг Төр, 10%-ийг хувьцаа эзэмшигчид тус тус эзэмшдэг. Шивээ Овоогийн хүрэн нүүрсний

ордын Шинэ Усны хэсгийн 4290 га талбайд төрийн өмчит “Эрдэнэс монгол” ХХК тусгай зөвшөөрөлтэй (ТЗ) үйл ажиллагаа явуулж байна.

Шивээ Овоогийн ордын хүрэн нүүрсний ордын бусад хэсгүүдэд “ЭЙКУСОРА” ХХК тусгай зөвшөөрөл эзэмшдэг.

Хайгуулын талбайн физик газарзүйн байрлал

1980-аад оны сүүлээс Шивээ Овоогийн хүрэн нүүрсний ордын хэмжээнд хайгуулын ажил эхэлж байсан бөгөөд тухайн үед уг орд нь Дорноговь аймгийн Сүмбэр сумын нутагт харъяалагдаж байсан ч одоогийн засаг захиргааны нэгжийн шинэчилсэн хувиарлалтаар Говьсүмбэр аймгийн нэг сум болжээ. Уг орд нь Говьсүмбэр аймгийн Сүмбэр сумаас (төмөр замын Чойр өртөө) зүүн-өмнө зүгт 20км-т, Чойр-Нялгын нүүрсний сав газрын зүүн-хойд хэсгийг эзлэн байршина.



Зураг-1 Судалгааны талбайн ашиглалтын тусгай зөвшөөрлүүдийн зураг

Стратегийн ач холбогдол бүхий Шивээ Овоогийн хүрэн нүүрсний орд дээрх “Шивээ Овоо” ХХК-ний эзэмшиж байгаа 901А тусгай зөвшөөрлийн талбайн газарзүйн цэгүүдийн солбицлууд:

Хүснэгт-№2

Д/д	Байгууллагуудын нэр	Цэгүүд/ дугаар	Газарзүйн солбицол	
			Уртраг град мин сек	Өргөрөг град мин сек
1	Шивээ Овоо ХК	1	108 32 27	46 13 05
2	Шивээ Овоо ХК	2	108 32 27	46 13 32
3	Шивээ Овоо ХК	3	108 31 45	46 13 32
4	Шивээ Овоо ХК	4	108 31 45	46 13 17

5	Шивээ Овоо ХК	5	108 31 25	46 13 17
6	Шивээ Овоо ХК	6	108 31 25	46 13 05

Стратегийн ач холбогдол бүхий Шивээ Овоогийн хүрэн нүүрсний орд дээрх “Эрдэнэс Монгол” ХХК-ний эзэмшиж байгаа 13311А тусгай зөвшөөрлийн талбайн газарзүйн цэгүүдийн солбицлууд:

Хүснэгт-№3

Д/д	Байгууллагуудын нэр	Цэгүүд/ дугаар	Газарзүйн солбицол	
			Уртраг град мин сек	Өргөрөг град мин сек
1	“Эрдэнэс Монгол” ХХК	1	108 30 31	46 13 49.36
2	“Эрдэнэс Монгол” ХХК	2	108 30 31	46 13 54
3	“Эрдэнэс Монгол” ХХК	3	108 31 36	46 13 54
4	“Эрдэнэс Монгол” ХХК	4	108 31 36	46 15 19
5	“Эрдэнэс Монгол” ХХК	5	108 36 41	46 15 19
6	“Эрдэнэс Монгол” ХХК	6	108 36 41	46 13 05
7	“Эрдэнэс Монгол” ХХК	7	108 32 27	46 13 05
8	“Эрдэнэс Монгол” ХХК	8	108 32 27	46 13 32
9	“Эрдэнэс Монгол” ХХК	9	108 31 45	46 13 32
10	“Эрдэнэс Монгол” ХХК	10	108 31 45	46 13 17
11	“Эрдэнэс Монгол” ХХК	11	108 31 25	46 13 17
12	“Эрдэнэс Монгол” ХХК	12	108 31 25	46 13 05
13	“Эрдэнэс Монгол” ХХК	13	108 31 08	46 13 05
14	“Эрдэнэс Монгол” ХХК	14	108 30 45	46 13 23

Стратегийн ач холбогдол бүхий Шивээ Овоогийн хүрэн нүүрсний орд дээрх “Эрдэнэс Монгол” ХХК-ний эзэмшиж байгаа 13312А тусгай зөвшөөрлийн талбайн газарзүйн цэгүүдийн солбицлууд:

Хүснэгт-№4

Д/д	Байгууллагуудын нэр	Цэгүүд/ дугаар	Газарзүйн солбицол	
			Уртраг град мин сек	Өргөрөг град мин сек
1	“Эрдэнэс Монгол” ХХК	1	108 31 08	46 13 05
2	“Эрдэнэс Монгол” ХХК	2	108 36 41	46 13 05
3	“Эрдэнэс Монгол” ХХК	3	108 36 41	46 12 06
4	“Эрдэнэс Монгол” ХХК	4	108 33 40	46 12 06
5	“Эрдэнэс Монгол” ХХК	5	108 33 40	46 11 29
6	“Эрдэнэс Монгол” ХХК	6	108 33 24.81	46 11 29

Стратегийн ач холбогдол бүхий Шивээ Овоогийн хүрэн нүүрсний орд дээрх “Эрдэнэс Монгол” ХХК-ний эзэмшиж байгаа 13313А тусгай зөвшөөрлийн талбайн газарзүйн цэгүүдийн солбицлууд:


Хүснэгт-№5

Д/д	Байгууллагуудын нэр	Цэгүүд/ дугаар	Газарзүйн солбицол	
			Уртраг град мин сек	Өргөрөг град мин сек
1	“Эрдэнэс Монгол” ХХК	1	108 30 31	46 12 43.89
2	“Эрдэнэс Монгол” ХХК	2	108 32 19.81	46 11 29
3	“Эрдэнэс Монгол” ХХК	3	108 30 31	46 11 29

Улаанбаатар-Сайншандыг холбосон төмөр зам болон засмал магистраль замууд нь “Эрдэнэс Монгол” ХХК-ний эзэмшилд байгаа тусгай зөвшөөрлийн гурван талбайнууд, Шивээ Овоогийн хүрэн нүүрсний ордын нүүрсний нөөцтэй талбай дээгүүр шууд нэвтрэх бөгөөд тус ордын үйлдвэрлэлийн ихэнх нөөцийг агуулж байгаа Шинэ-Усны хэсэг нь төмөр замын магистралийн зүүн хойд хэсэгт бүхэлдээ байрладаг.



Зураг.2 Судалгаанд хамрагдсан газрын байршлын зураг



Зураг-3. Шивээ-Овоогийн нүүрсний ордын бүрэлдэхүүн хэсгүүд, дэд бүтцийн байдал

Газрын гадаргын хэлбэршлийн хувьд Чойр-Нялгын сав газар нь намхан уул толгодоор хүрээлэгдсэн зүүн талаараа дугуйрсан гадагшаа гарцгүй хотгор хөндий бөгөөд түүнийг хүрээлж байгаа уул, толгод нь базальт, боржин гэх мэт галт уул, маагмын гаралтай гүний чулуулгууд, элсэнчулуу, гравелит, хөрсөн зэрэг хурдас хуримтлалын гаршаас бүрдэх ба тэдгээр уулсын үнэмлэхүй өндөр нь 1180-1230м-т хэлбэлзэнэ.

Дүүргийн хэмжээнд эх газрын эрс тэс уур амьсгалтай, зун нь халуун үргэлжлэх хугацаа богино, өвөл нь урт, хүйтэн -35° хүрдэг ба хөрсөндөө -40° хүрнэ.

Газрын хөрс өвөлдөө 2-4 м хүртэл гүн хөлдөх ба цасан бүрхүүл багатай хуурай байдаг. Салхины чиглэл үндсэндээ баруун хойноос зонхилох бөгөөд хурд нь 6,0-20,0 м/сек заримдаа 40,0 м/сек хүрэх тохиолдол байдаг.

Уур амьсгал: Шивээ Овоогийн нүүрсний орд орчим нь Төв Азийн геоморфологийн их мужийн дорнод дэдмужид хамаардаг, гандуу дулаан зунтай, хүйтэн өвөлтэй, хээрийн бүсэд багтана. Цаг уур, уур амьсгалын үндсэн үзүүлэлтийг ордод хамгийн ойр байрлах Чойрын цагуурын станцын ажиглалтын материалд тулгуурлан авлаа. Уур амьсгалын гол хүчин зүйл болох агаарын температурыг авч үзвэл ордын байрлалын районд жилийн дундаж агаарын температур 2.3 С, хамгийн дулааны улирал болох 7 дугаар сарын агаарын дундаж температур 21.1 С, хамгийн хүйтэн 1 дүгээр сарын агаарын дундаж температур - 19.3 С байна.

Орд орчмын агаарын дундаж температур (сар, жилээр)

Хүснэгт-№6

Сар	I	II	III	IV	V	VI	VII	VIII	IX	X	XI	XII	ж/д
ТемпературС	-19,3	-12,4	-7,8	6.1	11,3	19,7	21,1	17,9	11,3	3,4	-7,8	-16,7	2,3



Зураг-3. Агаарын дундаж температурын жилийн явц


Эндээс үзэхэд хоногийн дундаж агаарын температур 00С-ээс их байх хугацаа IV-X саруудад үргэлжилнэ. Нутгийн хойд, зүүн, төвийн хэсгээр 250 - 300 мм, баруун хэсгээр 200 - 250 мм, баруун өмнөд хэсгээр 150 - 200 мм тунадас унадаг. Хүйтний улиралд хойд хэсгээр 10-20 мм, өмнөд хэсгээр 5 – 10 мм, дулааны улиралд хойд хэсгээрээ 200 — 300 мм, өмнөд хэсгээрээ 100 - 200 мм тунадас дунджаар унадаг. Жилийн IX дүгээр сарын 20-оос XII дугаар сарын 1-ний хооронд тогтвортой цасан бүрхүүл үүсдэг. Цасан бүрхүүлийн дундаж зузаан 10 мм, дунджаар 3 дугаар сарын 1-ээс цасан бүрхүүл ханзарч эхлэх бөгөөд тогтвортой цасан бүрхүүл 100 орчим өдөр үргэлжилнэ. Харин гуу жалга хотгор хэсгүүдэд цасны хучаасын зузаан 1 м хүртэл нэмэгддэг. Хавар эхлэнгүүт цас хайлж хөрсний доорх усыг тэжээдэг онцлогтой. Уур амьсгалын өөрчлөлтөд салхины хурд, хүчтэй салхитай өдрийн тоо, агаарын бохирдолт, тоосжилт гол гол нөлөө үзүүлдэг. Хүчтэй салхи гол төлөв IV-V саруудад тохиолддог байна. Тухайн бүсд 15 м/с ба түүнээс хүчтэй салхитай өдөр 10 - 20, жилд ойролцоогоор 5 өдөр цасан шуургатай байна.

Уур амьсгалын өөрчлөлтөд салхины хурд, хүчтэй салхитай өдрийн тоо, агаарын бохирдолт, тоосжилт зэрэгт гол нөлөө үзүүлдэг. Хүчтэй салхи гол төлөв IV-V саруудад тохиолддог байна. Тухайн бүсд 15 м/с ба түүнээс хүчтэй салхитай өдөр 10 - 20, жилд ойролцоогоор 5 өдөр цасан шуургатай байна.

Зүгчиг	Х	ЗХ	З	ЗӨ	Ө	БӨ	Б	БХ
Давтагдал%	20	8	4	16	4	4	4	40

Ус зүй. Шивээ Овоогийн хүрэн нүүрсний ордын талбайн хэмжээнд байнгын үйл ажиллагаатай усан сүлжээ байхгүй бөгөөд зөвхөн ширүүн аадар борооны болон цасны шар усны үерийн үед сэргэж дараа нь хатдаг хуурай сайр, тойрмууд хөгжсөн байдаг. Оршин суугчид нь унд усныхаа хэрэгцээг зөвхөн худгаас хангадаг.

Хөрс. Говьсүмбэр аймгийн Шивээговь сумын нутаг дахь “Эрдэнэс Монгол” ХХК-ний 13311А, 13312А тусгай зөвшөөрөл бүхий талбайн байрлах нутаг дэвсгэр нь газар зүйн мужлалаар Хангайн их мужийн өргөргийн бүсшилийн Бүрд-Баянцагааны хүрэн хөрсний 3-р тойрог, Бор-өндөр-Уулбаяны 6-р тойргийн зааг, говийн их мужийн Баяндэлгэрийн цайвар хүрэн хөрсний 8-р тойргийн хойд хэсэгт хамрагддаг онцлогтой. Энэхүү тойрогт тал хөндийн цайвар хүрэн, /kastanozems/ хүрэн /aridic kastanozems/ хөрсний хэв шинжүүд тус тус тархана. (Монгол Улсын Үндэсний атлас, 2009).



Зураг-4. Хөрс газарзүйн мужлал, талбайн байршил

Хөрсний хээрийн судалгаагаар 13311А, 13312А ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий талбай нь ерөнхийдөө тэгшивтэр газрыг хамран байрлах бөгөөд далайн түвшинээс дээш 1188-1200 метрийн өндөрт орших тухайн эдэлбэр газарт дараахи үндсэн хэв шинж, дэд хэв шинж, төрөл, дүрсийн хөрс тархсан байдаг. Үүнд:

Нам уул толгодын цайвар хүрэн хөрс. Судалгаанд хамрагдсан талбайн нам уулс, толгодын хэсгээр нимгэн хүрэн хөрс тархах ургамлын нөмрөгт алаг өвс-үетэнт, үетэнт-алаг өвс, сөөгт бүлгэмдэл бүхий зүйлийн бүрдлээр ядуувтар, сийрэг ургасан хуурай хээрийн ургамалжил зонхилж газрын гадаргын 10-30%-ийг бүрхэнэ. Хөрс үүсгэгч эх чулуулаг нь гол төлөв делюви, элюви-делювийн гаралтай сайр чулуурхайг хурдас байна.

Сул хөгжилтэй элсэнцэр хүрэн хөрс. Хөрсний гадарга ямар нэгэн хэмжээгээр элсээр бүрхэгдсэн байх бөгөөд гандмал бордуу өнгөтэй, хялбар бутардаг, хэврэг нимгэн өнгөн үеэр эхэлнэ.

Далд глейрхэг хүрэн хөрс. Хүрэн хөрсний хил зааг дотор нам доор хэсгээр тархах ба ургамалжилт нилээн сайн байдаг онцлогтой.

Ургамлын аймаг. Эрдэнэс Монгол ХХК-ий ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий талбай орчим нь Монгол орны ургамал газар зүйн мужлалаар Евразийн хээрийн их мужийн Дундад халхын дэд мужид хамрагдана. /Монгол Улсын Үндэсний атлас 2009 он/. Судалгаанд хамрагдсан талбай нь нам хотос тэгшивтэр газар байна. Энд говь хээрийн ургамалжилт зонхилно. Зонхилох ургамал нь *Caragana microphylla*, *Stipa krilovii*, *Elymus chinensis*, *Artemisia frigid*, *Cleistogenes squarrosa*, *Carex duriscula* оролцоно. Шивээ-овоо орчимд дэрс-хялганат, хазаар өвс-хялганат, харгана-алаг өвс-шарилжит бүлгэмдэлүүд тархана. Судалгааны объектийн бэлчээрийн хэв шинжийг бүрдүүлэгч төрлүүд нь ургамалын дундаж өндөр 8-25 см, ерөнхий бүтэц 30-40 хувь байх ба аж ахуйн бүлгээр нь ангилж үзэхэд үетэн 20, алаг өвс 35, буурцагтан 45 орчим хувийг эзэлж байна. Энд ургамлан нөмрөгийн тусгагын бүрхэц нь 30-35% байна. Зонхилох ургамал нь *Stipa krilovii*, *Stipa gobica*, *Allium polyrrhizum*, *Artemisia frigida* оролцоно. Шивээгийн нүүрсний уурхайн орчимд *Caragana pygmaea* бүхий сөөгт агь – таана хялганат бүлгэмдэл зонхилон тархаж байна. *Caragana pygmaea* *Stipa gobica* *Allium polyrrhizum* *Cleistogenes squarrosa* *Agropyron cristatum* *Artemisia frigida* *Kochia prostrata* *Carex korshinskyi* зэрэг зүйл ургамлууд зонхилоно. Түүнчлэн Шивээ овоогийн нүүрсний уурхайн орчмын ургамлан нөмрөг хүн, машин механизмын нөлөөгөөр ургамлан бүрхэвч нэлээд их талхлагдсан. Зүйлийн бүрэлдэхүүнд бэлчээр тэжээлийн шимт чанараар муу ургамал зонхилох болсон байна. Эндхийн ургамлан нөмрөг сийрэг тарчиг, зүйлийн бүрдэл нь *Salsola collina*, *Salsola palicifolia*, *Chenopodium album*, *Chenopodium aristatum*, *Tribulus terrestris* *Artemis scoraria* зэрэг цөөн наст ургамлууд ургаж байна.

Амьтны аймаг. Ховор амьтнаас аргаль, янгир, бусад амьтадаас цагаан зээр, үнэг, чоно, говийн болон тал хээрийн усны шувууд нутагладаг. Сансараас авсан гадаргын бүрхэвчийн зургаас үзвэл бараг бүх нутаг нь хээр, харин өмнөд хэсгийг говийн бүс эзэлж байна.

Нүүрсний нөөц

Шивээ Овоогийн нүүрсний ордын нийт геологийн нөөцийг А, В, С1, С2, P1, P2 зэргээр тооцоолон 2'809.9 сая тн-оор тогтоосон байна. Үүнээс Шинэ-Усны хэсгийн нарийвчилсан хайгуулаар тогтоосон нөөцийг Хүснэгтэнд үзүүлэв.

Ордын Шинэ-Усны хэсгийн нүүрсний нөөц

Хүснэгт №7

Давхаргын дугаар	Балансын нөөц, мян.тн					Балансын бус	Бүгд
	А	В	А+В	С1	А+В+С1	С2	
I	11153.3	186196.1	197349.4	103526.2	300876.6	22236.5	323112.1
II	15605.1	57980.2	73585.3	99912.7	173498.0	20988.0	194486.0
IIA	--	--	--	27464.9	27464.9	291.6	27756.5
Доод давхарга	26758.4	244176.3	270934.7	230903.8	501838.5	43516.1	545354.6
V	--	9978.8	9978.8	23279.0	33257.8	11749.3	45007.1
VA	--	--	--	16636.4	16636.4	15955.9	32592.3

VI	--	--	--	4239.5	4239.5	6094.1	10833.6
VIА	--	--	--	3304.8	3304.8	3685.4	6990.2
VII	--	--	--	3093.5	3093.5	309.5	3903.0
VIII	--	--	--	1720.4	1720.4	634.6	2855.0
Дээд давхарга	--	9978.8	9978.8	52273.6	62252.4	38928.8	10118.2
Нийт	26,758.4	254,155.1	280,913.5	283,177.4	564,090.9	82,444.9	646,535.8

Нүүрсний нөөцийг геологийн блокийн аргаар А, В, С1 зэргээр тооцоолжээ.

Шинэ-Усны хэсгийн нүүрсний нийт нөөц нь 646.53 сая тн бөгөөд балансын нөөц нь 564.1 сая тн байна. Нүүрсний нөөцийг зэрэг тус бүрээр авч үзвэл: А=26.8 сая тн, В=254.1 сая тн, С1=283.2 сая тн, балансын бус исэлдсэн нүүрс С2= 82.4 сая тн байна.

Ногоон нуур, Өехийн цагаан нуур зэрэг бусад талбайд нийт 2,144.6 сая тн нүүрсний нөөцийг урьдчилсан байдлаар тооцоолсон. Үүнд: С2=289.7 сая тн, Р1=958.8 сая тн, Р2= 896.1 сая тн байна.

2. УУРХАЙН АШИГЛАЛТЫН ТЕХНОЛОГИ, АЖИЛЛАХ ГОРИМ, КАЛЕНДАРЧИЛСАН ТӨЛӨВЛӨГӨӨ

Шивээ Овоогийн нүүрсний уурхайн хайгуулын шугамын дагуу I, II давхаргыг ашиглаж байна. Давхаргууд нь энгийн тогтоцтой 5-7 м зузаан хоосон чулууны үеэр зааглагддаг. Хоёр давхаргын нийлбэр зузаан дунджаар 21-26 м, давхаргууд 6^0-8^0 орчим уналтай. Нүүрсний давхаргын ул нь саарал өнгийн алевролит, аргиллит зэрэг чулуулагуудаас үелэн тогтсон байна. Алевролитын эзлэхүүн жин 1.81-2.06 г/см³, дунджаар 1.92 г/см³.

Уурхай нь жилийн турш хоногт 12 цагаар 2 ээлж ажиллана. Цаг агаарын гэнэтийн тааламжгүй нөхцлөөс болж ажил саатах, бусад хүчин зүйлээс хамааруулан уурхайн жилд дунджаар 350 хоног тасралтгүй ажиллаж байна.

Уурхайн ажиллах горим

Уурхай нь жилийн турш хоногт 8,5 цагийн үргэлжлэлтэй 2 ээлжээр ажиллана. Мөн цаг агаарын гэнэтийн тааламжгүй нөхцлөөс болж ажил саатах хоногийг хасаж тооцоолов. Тоног төхөөрөмжийн урсгал болон үндсэн засварын хугацааг тоног төхөөрөмжийн төрөл зүйл, хүчин чадлаас хамааруулан бүтээлийн тооцоонд хасаж өгөв. Төлөвлөгөөнд уурхайн ажиллах хоногийг дараахь байдлаар тогтоов.

Үүнд: Жилийн хоног – 365

Цаг агаарын нөхцлөөс саатах хоног – 5

Хоногт ажиллах ээлжийн тоо – 2

Ээлжийн үргэлжлэх хугацаа – 12 цаг

Баяр ёслолоор амрах хоног – 10 хоног

Уурхайн ажиллах хоног: $365 - 5 - 10 = 350$ хоног болно.

2023 оны уулын ажлын төлөвлөгөө

2023 онд 2295.0 мян.тн нүүрс олборлон, 2295.0 мян.тн борлуулж, нийт хөрс хуулалт 9530.0 мян.м³ үүнээс тээвэргүйгээр 2000.0 мян.м³, тээвэртэйгээр 7530.0 мян.м³, хөрс

дахин шидэлт 3257.0 мян.м3, автын инженер ажил 500.0 мян.м3, автын бус инженер ажил 1106.4 мян.м3 ажлуудыг хайгуулын XIX- IV, IX-XV шугамын хооронд гүйцэтгэхээр төлөвлөгдсөн.

Тээвэргүй хөрс хуулалт

Тээвэргүй хөрс хуулалтанд ЭШ-25/90, ЭШ-11/70, нүүрс нээх ажил, ЭКГ-5А экскаватораар ажлын бус талын хөрс шидэж хөрс тээвэрлэлтийн зам талбай засах ажилуудыг тус тус гүйцэтгэнэ.

ЭШ-25/90 Алхагч экскаватор нь хайгуулын VII-X шугамын хооронд дунджаар 630 м фронтын урттай 65-75 м орлын өргөнтэй, 16, 20 м дэд доголлуудад хуваан 1299.1 мян.м3 хөрс хуулж, 2363.4 мян.м3 дахин шидэлт нийт 3662.5 мян.м3 уулын цулын ажил гүйцэтгэнэ.

ЭШ-11/70 Алхагч экскаватор нь хайгуулын XI-XIII шугамын хооронд дунджаар 420 м фронтын урттай 55-60м орлын өргөнтэй, 14, 16м дэд доголлуудад хуваан 700.9 мян.м3 хөрс хуулж, 893.6 мян.м3 дахин шидэлт нийт 1594.5 мян.м3 уулын цулын ажил гүйцэтгэнэ. Нийт тээвэргүйгээр 2000.0 мян.м3 хөрс хуулж, 3257.0 мян.м3 дахин шидэлт нийт 5257.0 мян.м3 уулын цулын ажил гүйцэтгэнэ.

Тээвэртэй хөрс хуулалт

Тээвэртэйгээр үндсэн хөрс хуулалтанд ашиглалтын 3-р амны баруун жигүүрт I-IV суулт, ашиглалтын 2-р амны I-V суултын хөрсний дунджаар 9.5м-ийн өндөртэй доголлуудад ЭШ 11/70 болон ЭШ 25/90 алхагч экскаваторуудын 2023 онд нүүрс нээж ажиллах мөн 2024 онд шилжин ажиллах фронтуудыг бэлтгэх мөн ашиглалтын 3-р амны зүүн жигүүрт автотээвэртэйгээр нүүрс нээх зорилгоор 5510.0 мян.м3, нүүрсний үе давхарга хоорондын 1970.0 мян.м3 завсрын хөрс ангилан ялгаж хуулах болон ашиглалтын 3-р амны түрүүлэгч мөргөцөг ахих талбай, гадаад овоолго шинээр үүсэх талбайнуудаас 50.0 мян.м3 шимт хөрс хуулах ажлуудыг тус тус гүйцэтгэнэ.

Нийт 7530.0 мян.м3 хөрсийг дараах хослолуудаар гадаад болон дотоод овоолгод дунджаар 2.6 км талын зайд тээвэрлэнэ.

Үндсэн хөрс хуулалтанд РС-1250 гидроэкскаватор болон ЭКГ5А, ЭКГ10И шууд утгуурт цахилгаан экскаваторууд HD-465 /55тн/, САТ-773 /55тн/, Белаз75137 /130тн/ автосамосвалуудын хослолоор, завсрын хөрс хуулалтанд РС-1250, САТ-345D, ДХ-500 гидроэкскаваторууд САТ-773 /55тн/, HD-465 /55тн/ автосамосволын хослолоор тус тус ажиллана.

Шимт хөрс

2023 онд зүүн хойд чиглэлд үүсэх гадаад овоолгын талбай болон ашиглалтын 2, 3-р амны зүүн баруун жигүүрийн ахилтын талбайгаас нийт 50.0 мян.м³ шимт хөрсийг хуулж, 2021, 2022 онуудад техникийн нөхөн сэргээлтээр хэлбэршүүлсэн гадаад, дотоод овоолгын талбайд хучилт хийх мөн бусад биологийн нөхөн сэргээлт хийх зам талбайн тохижилтын нөхөн сэргээлтэнд ашиглахаар төлөвлөв.

Инженер ажил

Автотээвэртэйгээр нүүрсний доголын ажлын бус хажуугийн хана зааглах, дотоод овоолгоор тээврийн зам засах, болон бусад ажлуудад 500.0 мян.м³, автын бусаар дотоод овоолгийн гурвалжингийн нүүрсийг зааглаж шидэх, дотоод олборлолтын зам траншей суулгах 1106.4 мян.м³ нийт 1606.4 мян.м³ инженер ажил хийж гүйцэтгэнэ.

Технологи ажиллагааны процесс

Шивээ Овоо ХК-ны технологийн үйл ажиллагаа нь дараах шатлалаар явагдана.

1. Уурхайн талбайн хатаалт /ус шүүрүүлэлт/

Уурхайн гүний усыг карьерийн талбайгаас шахаж зайлуулна. Зайлуулж буй усныхаа ихэнх хэсгийг хаялагын нуурыг сэргээх, карьерийн зам талбайн тоосжилтыг дарах, нөхөн сэргээлтийн мод, бут, сөөг тарих г.мэт байгаль орчноо хамгаалах ажилд хэрэглэж байна.

2. Шимт хөрс хуулалт

Шимт болон шимэрхэг хөрсний зузааныг тодорхойлж түүнийг дугуйт ачигч, түрэгч, бульдозероор хуулж экскаватораар ачиж нөхөн сэргээлтийн талбайд ашиглах ба барилга байгууламж мөн эвдэрсэн газар нөхөн сэргээх зэрэгт ашиглагдана.

3. Өрөмдлөгийн ажил

Карьерийн доголуудыг үечилэн өрөмдлөгийн талбайг тэгш сайтар засаж бэлтгэнэ чулуулгийн хатуулгаас хамаарч параметрийг тодорхойлж өрөмдлөгийн ажил гүйцэтгэнэ.

4. Тэсэлгээний ажил

Өрөмдөгдсөн талбайд ажиллах техник, тоног төхөөрөмжөөс хамааран тэсрэх бодис тээвэрлэх, цэнэглэх, тэслэх ажлуудыг гүйцэтгэж чулуулгийг сийрэгжүүлнэ.

5. Ухаж ачих ажил

5.1 Нүүрс олборлолт

Уурхайн карьерийн бэлтгэгдсэн ам траншейн зам талбайгаар нүүрсийг экскаватор автосамосвалын хослол, автосамосвал конвейерийн хослолоор ухаж ачиж ТДХ-ийн вагон ачилтын бутлуур болон агуулах руу тээвэрлэнэ.

5.2 Тээвэргүй хөрс хуулалт

Ашиглагдсан орон зайд дотоод нөхөн дүүргэлтийг тээвэргүйгээр драглайн төрлийн экскаватораар гүйцэтгэх ба нүүрсний хил заагийг гаргана.

5.3 Тээвэртэй хөрс хуулалт

Уурхайн карьерийн гадаад болон дотоод орон зайд экскаватор автосамосвалын хослолоор ухаж ачиж сайтар бэлтгэгдсэн ам траншейгаар овоолго руу чулуулгийг тээвэрлэнэ.

6. Борлуулалт

Авто болон төмөр замаар нүүрсийг дулааны 4-р цахилгаан станцад болон бусад хэрэглэгчдэд борлуулна.

7. Нөхөн сэргээлт

7.1 Техникийн нөхөн сэргээлт

7.1.1 Техникийн нөхөн сэргээлтийг гүйцэтгэхдээ аюулгүй байдлын шаардлагыг ханган ажиллана. Үүнд:

7.1.1.1 Нурах эрсдэлтэй, суулт үүссэн нүх болон уурхайн доторх хонгилын тоог гаргана. Нурах эрсдэл хэт өндөр байгаа тохиолдолд энэхүү аргачлалын дагуу нөхөн сэргээлт хийхгүй байх.

7.1.1.2 Талбайд үүссэн овон товон гадаргууг тэгшлэх, налуу гадаргууг орчных нь гадаргуугийн хэлбэр төрхтэй ойртуулан хэлбэршүүлэх, тогтворжуулах арга хэмжээ авах.

7.1.1.3 Усны урсгалын нөлөөгөөр элэгдэлд өртөж болзошгүй бол усны элэгдлээс сэргийлэх, хөрсний тогтвортой байдлыг хангах зорилгоор олборлолтоос үүссэн овоолго материал, чулуулгаар дүүргэлт хийх. (Хэлбэржүүлэхдээ налууг зохих өнцгөөс хэтрүүлэхгүй байх).

7.1.1.4 Уурхайн бага оврын техник ашиглан, овоолго, хаягдал чулуулаг, хана мөргөцгийн оройг намсгаж, хэлбэршүүлэх, дүүргэлт хийсэн талбайг тэгшлэх.

7.1.1.5 Уурхайн тоног төхөөрөмж, машин техник ашигласны улмаас дагтаршиж, нягтарсан хөрсийг сийрэгжүүлэх.

7.1.1.6 Техникийн нөхөн сэргээлт хийсэн газрын гадаргууг эхлээд хөрсөн доорх шимтлэг шороогоор дараа нь хадгалсан шимт хөрсөөр хучиж биологийн нөхөн сэргээлт хийхэд тохиромжтой байх нөхцөлөөр хангах.

7.1.2 Техникийн нөхөн сэргээлтийн хамгийн сүүлчийн үе шат

7.1.2.1 Дээр дурьдсан бүх үе шатны ажлыг хийж дууссан гадаргууг шимт хөрсөөр бүрэх шаардлагатай үе шат юм. Энэ тохиолдолд тусад нь овоолон хадгалсан шимт хөрснөөс ачиж тээвэрлэн гадаргуу дээрээ тарааж байршуулна.

7.1.2.2 Техникийн нөхөн сэргээлтэнд шимт хөрсийг хуулж хадгалах, эвдэрсэн газар, овоолго зам талбайг хэлбэршүүлэх, шимт хөрсөөр хучих, биологийн нөхөн сэргээлтийн үед үр суулгац, бордоо худалдан авах, усалгааны систем бий болгох, арчилж тордох, хашаа хамгаалалт барихад шаардагдах бүх ажлын явцад гарах нийт зардал орно.

7.2 Биологийн нөхөн сэргээлт

Эвдрэлд орсон газрыг унаган төрхөөр хэлбэршүүлж бэлтгэсэн талбайд үржил шимт олон наст ургамал зэргийг тарьж ургуулах. Биологийн нөхөн сэргээлтийн ажилд шаардагдах зардлуудыг Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын хамтарсан Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2-т заасныг үндэслэн, Засгийн газрын 2017 оны 151 дүгээр тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор 2017 оны 08 сарын 17-ны өдрийн А/226, А/182 дугаар тушаалын хавсралт болох нөхөн сэргээлт хийгдэх ажлын үнэлгээ тооцох аргачлал"-ын дагуу боловсруулна.

ТЕХНОЛОГИ АЖИЛЛАГААНЫ ПРОЦЕСС



Хаягдал бохирдолт

2023 онд уулын ахилтад өртөх геологийн нийт нөөц 2439.2 мян.тн, ашиглалтын нөөц 2295.0 мян.тн нүүрс олборлон борлуулахаар төлөвлөсөн. Үүнээс 1-р давхаргын нүүрс 1577.4 мян.тн, 2-р давхаргын 717.6 мян.тн нүүрс байна. Ашиглалтын 2-р амны VI-IX хайгуулын шугам хооронд олборлолт явуулахад 2-р давхарга нь 0.2-1.5 м зузаантай 4-5-н чулуулгийн үетэй учраас ангилан ялгахад хүндрэлтэй мөн Зүүн жигүүр ашиглалтын 3-р ам, суналын дагуу XII-XIII хайгуулын шугамын хооронд олборлолт явуулах 2-р давхарга нь 0.2-3.5 м зузаантай 8-10 чулуулгийн линз үетэй учраас 2-р давхаргын нүүрсний үеүдийг гидроэкскаватораар ангилан ялгаж олборлохоор төлөвлөсөн.

2023 онд ашиглалтад өртөх ашиглалтын MV-000901, MV-013311, MV-013312 дугаартай тусгай зөвшөөрлийн талбайд I давхаргын 4В, 5В, 9В, 12В, 21В, 35С, 6ш блок, II давхаргын 3В, 7В, 22В,31С 4ш блокоос нүүрс олборлон борлуулхаар төлөвлөв. Тухайн талбайд оногдох эдийн засгийн үр ашигтай нөөц, тодорхой нөхцөлд эдийн засгийн үр ашигтай нөөцийн нийт хэмжээ 54723.76 мян.тн, блокийн эзлэхүүн 45226.25 мян.м3, эзлэхүүн жин 1.21 тн/м3, уурхайн хэмжээнд уулын ахилтад өртөх I, II давхаргын геологийн нийт нөөц 2439.2 мян.тн, ашиглалтын нөөц 2295.0 мян.тн нүүрс олборлон борлуулж, хаядлын хэмжээ 155.5 мян.тн буюу 7.0%-ийн нүүрсний хаягдалтай, 11.3 мян.тн буюу 0.5 %-ийн бохирдолттой байхаар төлөвлөгдөж байна. ЭШ-25/90, ЭШ-11/70 алхагч экскаваторуудаар нүүрсний давхаргуудын ажлын бус талын заагийг гаргаж ханыг цэвэрлэж ажиллана.

3. Уурхайн тээвэр

Уурхайн дотоод тээвэр

Шивээ-Овоогийн уурхай хөрсийг тээвэргүй болон тээвэртэй хосолсон системээр, нүүрсийг тээвэртэй системээр тус тус явуулж байна. Хөрс хуулалт болон нүүрс олборлолтын ажилд ЭШ алхагч, ЭКГ-5А, ЭКГ-10И, РС-1250, САТ-345D, DX-500LCA экскаваторууд, Коматцугийн HD-465, САТ773, Белаз75137 автосамосвалын хослолыг ашиглаж байна. Одоогийн байдлаар технологийн автомашин 18 ширхэг байгаагаас 12 ширхэг хөрс, нүүрс тээвэрлэлтэнд ажиллаж байна. Эдгээр автомашинуудын 34% 10 жил, 66% нь 1-6 жил ашиглагдаж буй техникүүд байна.

2023 онд төлөвлөж байгаа уулын цулыг тээвэрлэхэд 24 ширхэг технологийн автомашинуудаас тогтмол 18 ширхэг ажиллахад үйлдвэрлэлийн үйл ажиллагаа хэвийн явагдана. Тус 18 ширхэг автомашины бширхэг нь 90-130тн даац бүхий автомашинаар төлөвлөгдсөн.

Хөрс тээвэрлэлт

Хөрсийг гадаад болон дотоод овоолгод хөрс тээвэрлэнэ. Тээвэрлэлтийн дундаж зай гадаад болон дотоод овоолгод дунджаар 2.3 км болно. Тээвэрлэх нийт хөрсний хэмжээ 7530.0 мян.м³ үүнээс шимт хөрс 50.0 мян.м³, үндсэн хөрс 5510.0 мян.м³, завсрын хөрс 1970.0 мян.м³ байна.

Нүүрс тээвэрлэлт

Нүүрс тээвэрлэлт нь уурхайн ашиглалтын 1, 2, 3-р амнаас авто замаар нүүрс буулган ачих байгууламж агуулах болон хатаах үйлдвэр хүртэл 1.7-4.5км, төмөр замаар Улаанбаатар хотын ДЦС- IV хүртэл 260 км 2295.0 сая.тн нүүрс тээвэрлэгдэнэ.

Уурхайн гадаад тээвэр

Шивээ-Овоогийн уурхайн бусад ажилд зориулж ажиллагсдыг зөөх автобус 6 ш, аж ахуйн хэрэгцээнд зориулж ачааны машин 2ш, кран, суудлын автомашинуудыг ашиглаж байна.

Уурхайн дотоод болон гадаргуугийн автозам

Уурхайн орох траншей болон гадаргуугийн технологийн автозам нь байгалийн ердийн хөрсөн хучилттай юм.

Автозамын ашиглалтын хэвийн нөхцөлд байлгах үүднээс гаршын улаан шаврыг дэвсэж арчилгаа хийнэ.

Уурхайн тоног төхөөрөмжүүдийн ашиглалтын байдал**Хүснэгт №10**

№	Машин, техникийн марк		Дугаар	Ашиглалтанд орсон огноо	Ашиглалтын норм хугацаа	Ашигласан хугацаа	Ашиглалтын өнөөгийн байдал
Технологийн авто машин							
1	Автосамосвал	CAT-773D	№17	2011.09.12	10 жил	11 жил	Муу
2	Автосамосвал	CAT-773D	№18	2011.09.12	10 жил	11 жил	дунд зэрэг
3	Автосамосвал	CAT-773D	№19	2018.06.01	11 жил	4 жил 5 сар	Муу
4	Автосамосвал	CAT-773D	№20	2018.06.01	12 жил	4 жил 5 сар	сайн
5	Автосамосвал	CAT-773E	№21	2018.09.01	13 жил	4 жил 1 сар	Сайн
6	Автосамосвал	CAT-773E	№-22	2018.09.01	14 жил	4 жил 1 сар	Сайн
7	Автосамосвал	CAT-773E	№-23	2019.09.17	14 жил	3 жил	Сайн
8	Автосамосвал	CAT-773E	№-24	2019.10.20	14 жил	3 жил	Сайн
9	Автосамосвал	Белаз 55тн	№01	2014.12.15	7 жил	8 жил	Муу
10	Автосамосвал	Белаз 55тн	№02	2014.12.15	7 жил	8 жил	Муу
11	Автосамосвал	Белаз 55тн	№03	2014.12.15	7 жил	8 жил	Муу
12	Автосамосвал	Белаз 55тн	№04	2014.12.15	7 жил	8 жил	Муу
13	Автосамосвал	Белаз 55тн	№05	2016.06.29	7 жил	6 жил	дунд зэрэг
14	Автосамосвал	Белаз 55тн	№06	2016.06.29	7 жил	6 жил	дунд зэрэг
15	Автосамосвал	Белаз 137тн	№01	2016.09.17	7 жил	6 жил	Сайн
16	Автосамосвал	Белаз 137тн	№02	2016.09.17	7 жил	6 жил	Сайн

17	Автосамосвал	Белаз 137тн	№03	2016.09.17	7 жил	6 жил	Муу
18	Автосамосвал	HD465-7R	№25	2020.12.16	7 жил	2 жил	Сайн
19	Автосамосвал	HD465-7R	№26	2020.12.19	7 жил	2 жил	Сайн
20	Автосамосвал	HD465-7R	№27	2020.12.13	7 жил	2 жил	Сайн
21	Автосамосвал	HD465-7R	№28	2020.11.19	7 жил	2 жил	Сайн
22	Автосамосвал	HD465-7R	№29	2020.12.16	7 жил	2 жил	Сайн
Хүнд машин механизм							
1	Усны машин	Terex TR50	№-02	2008.09..26	10 жил	13 жил	Муу
2	Усны машин	Terex TR60W	№03	2020.10.06		2 жил	Сайн
3	Бульдозер	D8R	№-03	2011,12,01	10 жил	10 жил	дунд зэрэг
4	Бульдозер	DT25	№-01	2015.08.31	10 жил	7 жил	Муу
5	Бульдозер	DT25	№-02	2019.01	10 жил	3 жил	Сайн
6	Бульдозер	DT25	№-03	2019.07.20	10 жил	3 жил	Сайн
7	Автогрейдер	SEM922	№-01	2018.09.13		4 жил	Сайн
8	Автогрейдер	SEM922	№-02	2019.06		3 жил	Сайн
9	Гидроэкскаватор	CAT -345	№-02	2011,12,01	10 жил	11 жил	дунд зэрэг
10	Гидроэкскаватор	DX-500		2015.01.20	8 жил	7 жил	Сайн
11	Автоашигч	DL550		2015.01.20	8 жил	7 жил	Сайн
Уулын тоног төхөөрөмж							
1	Цах- экскаватор	ЭКГ-5А	№-01	1991.06.10	16-20 жил	31 жил	Муу
2	Цах- экскаватор	ЭКГ-5А	№-03	1993.07.05	16-20 жил	29 жил	Муу
3	Цах- экскаватор	ЭКГ-5А	№-04	1994.05.14	16-20 жил	28 жил	Муу
4	Цах- экскаватор	ЭКГ-5А	№-05	2003.04.01	16-20 жил	19 жил	дунд зэрэг
5	Цах- экскаватор	ЭКГ-10И	№01	2016.09.17	16-20 жил	6 жил	Сайн
6	Алхагч экскаватор	ЭШ-25/90	№-01	2003.05.20	16-20 жил	19 жил	дунд зэрэг
7	Алхагч экскаватор	ЭШ-11/70	№-02	2014.09.15	10-15 жил	8 жил	дунд зэрэг
8	Өрмийн машин	DM-46E	№-7445	1998.04.01.	10 жил	24 жил	Муу
9	Өрмийн машин	DM-30-II		2018.04.28	10 жил	4 жил	Сайн
Тээвэр үйлчилгээний авто машинууд							
1	Суудлын автомашин	Landcruiser 200	94-07 УНЗ	2011.09.08	10 жил	11 жил	дунд зэрэг
2	Суудлын автомашин	Prado 150	92-26 ГСА	2013.10.18	6 жил	9 жил	Сайн
3	Суудлын автомашин	Landcruiser 79	10-21 УНЧ	2013.10.18	6 жил	9 жил	Сайн
4	Суудлын автомашин	Landcruiser 79	08-24 ГСА	2013.10.18	6 жил	9 жил	Муу
5	Суудлын автомашин	Landcruiser 79	08-23 ГСА	2013.10.18	6 жил	9 жил	Муу
6	Суудлын автомашин	Landcruiser 79	08-04 ГСА	2013.10.18	6 жил	9 жил	Муу
7	Хүн тээврийн автобус	HYUNDAI	41-18 УНЗ	2017.12.27	6.6 жил	5 жил	сайн
8	Хүн тээврийн автобус	HYUNDAI	40-25 УНЗ	2017.12.27	6.6 жил	5 жил	Сайн
9	Хүн тээврийн автобус	HYUNDAI	41-80 УНЗ	2019.06.14	6.6 жил	3 жил	Сайн
10	Хүн тээврийн автобус	HYUNDAI	41-36 УНЗ	2019.06.06	6.6 жил	3 жил	Сайн
11	Хүн тээврийн автобус	URAL	01-75 ГСА	2020.04.17		2 жил	Сайн
12	Хүн тээврийн автобус	URAL	01-85 ГСА	2020.04.17		2 жил	Сайн
13	Цистерн	Mitsubishi FP-517HL	14-83 ГСА	1999.04.01	12 жил	23 жил	муу
14	Цистерн	Зил-433362 КО-520	20-76 ГСА	2003.11.12	6 жил	19 жил	муу

15	Автокран	Tadano	1998.11.01	15 жил	24 жил	дунд зэрэг	
16	Автокран	Вышкатай	17-07 ГСА	2014.10.01	6 жил	8 жил	Сайн
17	Ачааны автомашин	Daewoo	94-49 ГСА	2012.09.12,	6 жил	10 жил	дунд зэрэг
18	Өөрөө буулгагч машин	FAW	63-07 ГСА	2015.04.23	6 жил	7 жил	муу
19	Цооног цэнэглэгч	BC LH-15 ANFO TRUCK	60-21 ГСА	2014.12.15	6 жил	8 жил	Дунд зэрэг
20	Ачааны машин	KIA RHNO	06-79 ГСА	2015.04.27	6 жил	7 жил	сайн
21	Фургон	УАЗ-220695-355	10-29 ГСА	2015.04.27	6 жил	7 жил	Дунд зэрэг
22	Погрузчик	HUNDAI CPC30E		2015.12.29	10 жил	7 жил	сайн
23	Өрмийн машин	CNHTC	08-83 ГСА	2014.03.10	10 жил	8 жил	сайн
24	Авто погрузчик	TCM FD100Z8		2000.08.24	10 жил	22 жил	муу
25	Ачааны автомашин	DAEWOO	94-49 ГСА	2012.09.12	6 жил	10 жил	дунд зэрэг

2023 оны овоолгын аж ахуй

Тээвэртэй хөрс хуулалтын ажил ашиглалтын 1, 2, 3-р амны баруун жигүүрүүдэд тус тус хийгдэхээр төлөвлөсөн. Ашиглалтын 1-р амны баруун жигүүрт хөрс хуулалтын ажил явах нь нүүрс олборлолтын тээврийн зайг багасган эдийн засгийн хувьд үр дүнтэй болж байна. Нийт 8465.0 мян м3 хөрс хуулах ба тээвэртэйгээр 6365.0 мян.м3 үүнээс 5365 мян.м3 нь гадаад овоолгын дээр дурдсан хэсэгт, үлдсэн 1000.0 мян.м3 нь хагарал гулсалттай талбайнуудыг нөхөн дүүргэх, техникийн нөхөн сэргээлтийн талбайг хэлбэршүүлэх зэрэг ажлуудад дотоод овоолгод бууж, 2100.0 мян.м3 нь тээвэргүйгээр өмнөх орлоор олборлолт хийсэн хоосон орон зайг нөхөн дүүргэж дотоод овоолго байгуулна.

Гадаад овоолгыг баруун хойд хэсгийн овоолгыг хөгжүүлэх, болон шинээр зүүн хойд чигт 10.5 га талбайд 18м өндөртэй 2200.0 мян.м3, 18м өндөртэй 1600.0 мян.м3 нийт 32м-ийн өндөртэй 3800.0 мян м3, овоолгийн хойд чиглэлд хөгжүүлэлтэнд 2555.0 мян.м3 хөрсний овоолгыг тус тус хийхээр төлөвлөсөн. Овоолгын талын дундаж зай 2.6 км байхаар байна. Овоолго байгуулах хэсгийн зургийг уулын ажлын төлөвлөгөөний өрнөлтийн зурагт буулгасан болно.

Дотоод овоолгод хөрсийг алхагч экскаватораар шууд шидэж овоолохын зэрэгцээ авто тээврээр зөөнө. Дотоод овоолгын тэгшилгээ, нягтруулалт, зам гаргах, дууссан хэсгийн техникийн нөхөн сэргээлт зэрэг ажлыг CAT D8R моделийн бульдозероор гүйцэтгэнэ.

Уурхайн ус шүүрүүлэх ажлын талаархи өнөөгийн байдал

Ус шүүрүүлэх нь 2022 оны 12-р сарын 31-ний байдлаар А, С, 16, D шугам болон карьерт жилийн дунджаар нийт 39 худаг ажиллаж, 3597.4 мян.м3 ус уурхайгаас зайлуулахаар төлөвлөснөөс нийт 32 худаг ажиллаж 78.2 %-тай 2321.2 мян.м3 ус уурхайгаас

зайлуулж биелэлт 64.5 %-тай, усны түвшинг хяналтын цооногуудын дунджаар оны эхнээс буурсан үзүүлэлтийг ашиглалтын ам тус бүрээр хархад I ам 1135.93 – аас 1134.59 түшинд - 1.39 м-ээр бууралттай, II ам 1125.16 – аас 1124.22 түшинд -0.94 м-ээр бууралттай, III ам 1122.89 – өөс 1122.16 түшинд -0.73 м-ээр буурсан байна. Уурхайн ашиглалтын I, II, III амуудын усны түвшингийн дундаж 1127.99 – 1126.97 түвшинд -1.02 м-ээр бууржээ.

2022 оны ус шүүрүүлэхийн төлөвлөгөөнд D41, D42, D43, D44, 4 ширхэг цооног 760 уртааш метр, өрөмдөж мантажлан ашиглалтад оруулхаас ашиглалтын D43, D44, дугаартай 2 ширхэг цооног 400 уртааш метр өрөмдөж мантажлан ашиглалтад оруулсан, 2022 оны зардлыг хэмнэх ажлын хүрээнд D41, D42, дугаартай ашиглалтын цооногуудыг өрөмдөлгүй хойшлуулсан. D43, D44-р худгийн салбар шугамын далан, шугам хоолойн дулаалга, хучилт хэлбэршүүлэлтын газар шорооны ажилд 1.0 мян.м³ хөрс орсон байна.

2023 онд ус шүүрүүлэх ажлын талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээ

2023 онд уурхайн нүүрс олборлолтын өрнөлт ашиглалтын 1-р ам XIX-III шугам хооронд уналын дагуу, 2-р ам суналын дагуу хайгуулын VII-X шугам, 3-р ам хайгуулын XI-XIII шугам хооронд унал, суналын дагуу I, II давхаргаас нийтдээ 2295.0 мян.тн нүүрс олборлон борлуулахаар төлөвлөсөн. I давхаргын 1577.4 мян.тн нүүрс Олборлоно дээрхи нүүрсний 25% нь усны хүндрэлтэй байгаа учраас карьерт нь зумпфын аргаар усыг шавхан зайлуулж нүүрсийг хуурайшуулж авна. 2023 онд нэмж D41, D42 нийт 2 ширхэг цооног өрөмдөж мантажлан ашиглалтанд оруулах нийт 405 уртааш метр өрөмдлөг, худгийн Ф-89мм-ийн салбар шугамын 300м урт далангийн газар шорооны ажилд 2.0 мян.м³ хөрс орох зэрэг ажлууд хийгдэхээр төлөвлөөд байна.

2023 онд ус шүүрүүлэх А шугамын 2, С шугамын 2, 16-р шугамын 3, D шугамын 32 ширхэг нийт 39 худаг, жилийн дунджаар 36 худаг ажиллан 3.6 сая.м³ усыг шавхан зайлуулахаар төлөвлөөд байна. Төлөвлөгөөт их засварын графикт ажлыг дулааны улиралд гүйцэтгэх II улиралд 17 худаг, III улиралд 24 худаг нийт 41 худагт их засвар, шавхалт цэвэрлэгээний ажил хийж гүйцэтгэхээр төлөвлөлөө.

Уурхайн / үйлдвэр / ус хангамж 2023 оны төлөвлөгөө

Умард говийн гүвээт халхын дунд талын сав газарт хамаарна. Усны эх үүсвэр, нөөц, чанар, хоногт ашиглах хэмжээ /шоо метрээр/

Ажиллагсдын унд-ахуйн хэрэгцээнд ашиглах 1.8 м³/хоног усыг уурхайн ажилчидын цайны газар, уурын зуухны зүүн тийш 120-130 метрт орших зориулалтаар цэвэр усны 21-р худаг 2.3 л/сек ундаргатай, нөөцийн зориулалтаар өрөмдөгдсөн 21-1 –р худаг нь 21-р худгаас 45 м-т байрлана.

Худгийн солибоцол 21-р худаг Х 308716.76 У 5122414.76

21-1 –р худаг Х 308704.82 У 5122382,12

Холбогдох хууль, дүрэм, журам, норм стандартын дагуу усны зарцуулалтыг тооцох, Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайдын 2015 оны А-301 дугаар тушаалаар баталсан “Нэгж бүтээгдэхүүн үйлдвэрлэх, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэхэд зарцуулах усны норм”-ын дагуу тооцвол: $180\text{хүн} \times 10 \text{ л/хон} \times 225 \text{ хоног} = 405.0 \text{ м}^3$ – унд-ахуйд хэрэглэх усны хэмжээ:

Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 20.1.1-д заасны дагуу биологийн нөхөн сэргээлт, зам, талбайн тоосжилтыг дархад усны хэрэглээг (гүний цооногийн аргаар шавхан зайлуулаж байгаа ус дамжуулах төв коллектор шугамаас эргүүлэн ашигладаг) зарцуулагдах нийт усны хэмжээ $50400 \text{ м}^3/\text{жил}$ “Усны тухай хуулийн 15, 20-р зүйл”-ийн 15.1 рашааны нөөц ашигласны төлбөрийн хувь хэмжээ, 20.2.2-д ан амьтан хамгаалах өсгөн үржүүлэх, нутагшуулах болон ургамал тарьж ургуулах замаар байгалийн баульгийг нөхөн сэргээх талбайг услах зэрэгт ашиглагдсан усны хэмжээ 21840 м^3 жил ус төлбөрөөс чөлөөлөгдөж байгаа хэдий ч шавхан зайлуулах усны төлбөрийн хэмжээнд орсон дүн болно.

Биологийн нөхөн сэргээлтэнд усны машин тооцоо:

Хоногт дунджаар 3 рейс * $40\text{м}^3 = 120\text{м}^3$

Жилд 182 хоног * $120\text{м}^3 = 21840\text{м}^3$

Замын тоосжилт Терех усалгааны машин тооцоо:

Хоногт дунджаар 5 рейс * $40\text{м}^3 = 200\text{м}^3$

Жилд 252 хоног * $200\text{м}^3 = 50400\text{м}^3 / 1260 \text{ рейс/}$

Дээрхи ажлыг Хятад улсын TEREХ маркийн 40тн, Dongfeng маркийн 20тн усны машинууд замын тоосжилт, нөхөн сэргээлтийн талбайд ашиглагдаж байна.

Шүүрүүлэх усны хэмжээ

Уурхайгаас шавхан зайлуулах 3597.5 мүн м³ шүүрлийн усны төлбөрийн хэмжээ “Усны экологи-эдийн засгийн үнэлгээг шинэчлэн батлах” тухай Засгийн газрын 2011 оны 302 дугаар тогтоолоор Умард говийн гүвээт-Халхын дундад талын сав газарт тогтоосон газрын доорх усны экологи-эдийн засгийн суурь үнэлгээ, “Тогтоолын хавсралтанд өөрчлөлт оруулах” тухай Засгийн газрын 2013 оны 09 дүгээр сарын 21-ний өдрийн 327 дугаар тогтоолд заасан ашиглалтын зориулалтыг тооцох итгэлцүүр, “Усны нөөц ашигласны төлбөрийн хувь хэмжээг тогтоох, хөнгөлөх” тухай Засгийн газрын 2013 оны 09 дүгээр сарын 21-ний өдрийн 326 дугаар тогтоолд заасан хувь, хэмжээг ашиглан урьдчилсан байдлаар тооцож төлбөр төлнө.

Уурхайгаас шавхан зайлуулж буй 1м^3 газар доорх усны нөөц ашигласны төлбөр:

$3700 \text{ төг/м}^3 \times 0.15 \times 0.3 = 166.5\text{м}^3/\text{төг}$

3700төг/м^3 - Умард говийн гүвээт-Халхын дундад талын сав газарт газрын доорх ус ашигласан нөхцөлд тогтоосон экологи-эдийн засгийн суурь үнэлгээ:

0.15 (15%) – Засгийн газрын 2013 оны 326 дугаар тогтоолын дагуу газрын доорх усны нөөц ашигласны төлбөрийн 7в-д /усыг шавхан зайлуулах/ заасан хувь, хэмжээ:

0.3 – Дотоодын хэрэгцээнд нийлүүлж буй нүүрсний олборлолтын шавхан зайлуулах зориулалтаар газрын доорх ус ашигласан нөхцөлд тооцох ашиглалтын зориулалтын итгэлцүүр.

2022 онд Төлбөр: $3,597,909.0\text{м}^3 \times 166.5\text{төг}/\text{м}^3 = 599,051,850$ төг / Таван зуун ерэн есэн сая тавин нэгэн мянга найман зуун тавин төгрөг/

Төсвийн тухай хуулийн 23.6.5-д заасны дагуу үйлдвэрлэл үйлчилгээний зориулалтаар ашигласан усны төлбөрийг Говь-Сүмбэр аймгийн төсөвт төвлөрүүлэх.

УУРХАЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЧИНД ГАРЧ БОЛЗОШГУЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

Уул уурхайн үйл ажиллагааны явцад газрын доорхи усны нөөцийн бохирдол, хомсдол, ургамлан нөмрөгийн өөрчлөлт, хөрсний элэгдэл, эвдрэл, геологийн тогтцын өөрчлөлт, зэрлэг ан амьтдын байршилт, тархалтын өөрчлөлт, байгалийн нөөцийн хомсдол, бэлчээрийн талбай багасах, эрчим хүчний хэрэглээ нэмэгдэх, тэрчлэн агаар, ус, хөрсний бохирдол үүсэх, химийн бодисоос үүдэн гарах нөлөөлөл зэрэг сөрөг нөлөөллүүд хамаарна.

Эдгээр сөрөг нөлөөллийг бууруулах болон арилгах арга хэмжээний үр дүн нь байгаль орчныг хамгаалах үйл ажиллагаа нь шинжлэх ухааны үндэслэл бүхий зохион байгуулалт, техникийн арга хэмжээнүүдийг цогц бүрдэл байх бөгөөд эдгээр арга хэмжээнүүдийг хэрэгжүүлснээр тухайн уулын үйлдвэр, түүний эргэн тойрон дахь бүс нутагт уулын ажлын явцад экологийн зөвшөөрөгдөх норм, норматив хангагдаж байх ёстой.

Орчны агаарт үзүүлэх нөлөөлөл

Тоосны бохирдол Хөрс хуулах, тэсэлгээ хийх, нүүрс ба хөрсийг ачиж буулгах, тээвэрлэх зэрэг үйл ажиллагааны явцад орчны агаарыг тоосоор бохирдуулах ба өртөж эвдрсэн талбай болон гадаад, дотоод овоолгын сул шороо нь салхи шуурганд тоос босох эх үүсвэр болно.

Нүүрс болон хөрс тээвэрлэлтийн авто замыг тогтмол усалж, хайргажуулаагүйгээс болж тоос босч орчныг бохирдуулна. Уурхайд тэсэлгээ хийснээс газар чичрэх, агаарын хэт даралт үүсэх болон агаарт тоос дэгдэх зэргээр сөрөг нөлөө үзүүлнэ.

Хорт хийн бохирдол Уурхайд тэсэлгээ хийх, нүүрсний шаталт явагдах, хүнд даацын машин техник (автосамосвал, бульдозер, экскаватор г.м)-ийн хөдөлгүүрээс гарах утаанд угаарын хий (CO), азотын дутуу исэл (N₂O), хүхэрлэг хий (SO₂) зэрэг хорт хий ялгаран гарна. Эдгээр хийнүүд зөвшөөрөгдөх хэмжээнээс хэтэрсэн тохиолдолд төрөл бүрийн хордлого үүсгэнэ.

Хөрсөнд үзүүлэх нөлөөлөл

Газрын эвдрэл Уулын нэгдсэн хэсгийн малталт явуулсан талбай, уурхайн гадна байгуулсан автын овоолго, нүүрс, хөрс тээвэрлэлтийн зам, ус шүүрүүлэлтийн цооногууд далан суваг, уурхайн хил, хамгаалалтын суваг болон уурхайн барилга

байгууламж зэргийг барьж байгуулах, ашиглах явцад газар эвдрэлд орж унаган төрхөө алдана.

Шимт ба шимэрхэг хөрсний хорогдол Уулын ажлын төлөвлөгөөний дагуу жилдээ 4-6 га талбайдахилт хийдэг. Шимт ба шимэрхэг хөрсийг 15-40 см хуулж, агуулах байгуулан хадгалах ба шууд хөрсжүүлэх талбайд авч нөхөн сэргээлтэд ашиглах явцад уг хөрсийг дутуу хуулах, хэт зузаанаар хуулж ул шороотой хольж бохирдуулах, шимт хөрсний агуулахыг шаардлага хангахгүйгээр байгуулах, ус бороо салхиар хийсч хорогдох, эргүүлэн нөхөн сэргээлтэд ашиглах хэмжээ нь багасах зэргээр сөрөг нөлөөлөл бий болно.

Ө нгөн хөрсний бохирдолт Уурхайд бензин, дизель түлш түгээх 2 станц, төрөл бүрийн тос хүлээнэвч хадгалах, түгээх складтай ба тосолгоо үйлчилгээний ажил эрхэлдэг хэсэг цех ажиллаж байна. Эдгээр нь барилга, байгууламжийн орчимд хаягдсан нефть бүтээгдэхүүнээр эргэн тойрны хөрс шороо бохирдох мөн бороо, цасны усаар угаагдан хөрсний усыг бохирдуулах нөлөөтэй.

Хог хаягдлаар бохирдох Уурхайн үйл ажиллагаа явуулахтай холбогдон ажилчдын хоолны газар, контор, халуун усны газар, үйлдвэрлэлийн цех хэсгүүдээс үйлдвэрийн хог хаягдал гардаг. Үүнийг ерөнхийд нь хуурай ба шингэн гэж ангилан үзвэл:

Хуурай хатуу хог хаягдал: Төрөл бүрийн төмрийн зоргодос, хаягдал хуучин сэлбэг хэрэгсэл, ган канат, барилгын засвараас гарах хог хаягдал, хуучин дугуй, туузан дамжуулагчийн тууз, уурхайн ашиглагдаагүй талбай болон овоолгын орчмын зам талбайд асгарсан нүүрс г.м.

Шингэн хог хаягдал: Ажилласан тос, цэвэрлэгээнд хэрэглэсэн бензин, түлш, дулааны станцын үнс, цэвэрлэгээний тунгаасан ус, технологийн дамжлагын ба цехүүдийн нойтон цэвэрлэгээний ус гэх мэт.

Гадаргын болон газрын доорхи усанд үзүүлэх нөлөөлөл

Ил аргаар нүүрс олборлох технологийн дагуу гүний усанд байгаа нүүрсийг олборлохын тулд цооногийн аргаар урьдчилан шүүрүүлж, усны түвшинг нүүрсний давхаргаас доош оруулах аргаар олборлолт явуулдаг. Гүний усны түвшин буурснаар уурхайлалтын орчны гадаргын болон хөрсний усны түвшин буурч, хөрсөнд хуурайшилт үүсэх нөлөөтэй.

Ургамлан нөмрөгт үзүүлэх нөлөөлөл

Шивээ-Овоогийн уурхайн үйл ажиллагааны явцад уурхайн карьер болон овоолгууд, уурхайн дэд бүтцийн объектуудыг барих явцад тухайн орчны ургамлан нөмрөг хөрстэй хамт хуулагдана.

Мөн замын тоос, шорооноос ургамлан нөмрөгийн өнгө зүс нь алдагдах, навчинд түлэгдэлт үүсэх, эрт унах эрсдлийг бий болгодог.

Ургамлын бүрхүүлд бохирдуулах бодисын хуримтлал бий болсноос түүний бодисын солилцооны хэм алдагдах, эсийн бүтцэд өөрчлөлт орох, фотосинтезийн идэвх буурах, өсөлт нь удаашрах, улмаар өсөлт нь бүрмөсөн зогсож ургахаа болих зэрэг байдал бий болдог байна.

Эндээс үзвэл ашиглалт явуулж буй хэсэгт ургамлын ургац, амьдрал бүрмөсөн устаж, зарим халцгай буюу талхлагдаж орсон хэсэгт хог ургамал ялангуяа шарилж ихээр ургаж, хүн амьтны амьсгалд тоосны харшил үүсэх нөхцөл болж байна.

Ургамлын бүрхэвч устаж үгүй болох нөхцөлд олборлолтын ажил дууссаны дараа уг нутгийн бэлчээрийн нөхөн сэргээх асуудал чухлаар тавигдана.

Амьтны аймагт үзүүлэх нөлөөлөл

Шивээ Овоогийн уурхайд ашиглалт явуулах нь амьтны аймаг, ялангуяа хөхтний байршил, тархац, тоо толгойд шууд нөлөөлнө.

Хүн, машин техникийн хөл хөдөлгөөн, дуу чимээ, гэрэл зэргээс орчин тойрны 2-3 км хүртэлх зайд байгаа зарим том хөхтөн дайжиж зайлна.

Уурхайн үйл ажиллагаанаас амьтны аймагт шууд үзүүлэх нөлөөлөл харьцангуй бага боловч амьтан устах дайжих, орчин тохигүйтэх зэрэг сөрөг нөлөөнөөс үүдэн амьтны аймагт дам нөлөө аль нэг хэмжээгээр зайлшгүй гардаг.

Жижиг мэрэгчээр хооллодог хөхтөн, шувууд тэжээлээ дагаж зурвас нутгийн орчноос холдоно.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний гол зорилго

Тус БОМТ нь “Шивээ Овоо”-гийн ил уурхайн хүрэн нүүрсний ордыг ашиглаж төвийн эрчим хүчний систем дэх томоохон хэрэглэгчдын нүүрсний хэрэгцээг чанар стандартын шаардлагад нийцсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэн хангах, улс болон орон нутгийн хөгжилд тодорхой хувь нэмэр оруулах зорилготой.

“Шивээ Овоо” ХК нь Байгаль орчны менежментийн төлөвлөгөөгөөр дараахь арга хэмжээг хэрэгжүүлэх зорилготой. Үүнд:

Уурхайн хэмжээнд байгаль орчны хуулийн нийцлийг хангах.

Нарийвчилсан үнэлгээний заалтуудыг хэрэгжүүлэх, хэрэгжүүлэх боломжтой эсэхийг бодит байдал дээр тодорхойлох, үнэлэлт дүгнэлт өгөх.

Шивээ Овоо ХК-ийн байгаль орчны бодлогыг хэрэгжүүлэх.

Байгаль орчинд үзүүлэх нөлөөлөл

Хүснэгт №13

Байгаль орчны үзүүлэлт	Шууд	Шууд бус	Өөрөө зохицуулагддаг	Богино хугацааны	Урт хугацааны	Буцаж нөлөөлөх	Буцалтгүй нөлөөлөх	Хүчтэй	Дунд зэрэг	Бага зэрэг
Байгаль орчны бүрдэл хэсгүүдийн өөрчлөлт										
Гүний усны нөөц хомсдох			x							
Газрын доорхи усны чанарын өөрчлөлт			x							
Ургамлын бүтцийн өөрчлөлт	x		x		x	x			x	
Хөрсний элэгдэл, эвдрэл	x				x		x	x		
Геологийн тогтоцын өөрчлөлт	x				x		x	x		
Зэрлэг амьтдын орон зайн өөрчлөлт	x			x		x				x
Уур амьсгалын (бичил) өөрчлөлт			x							x
Байгалийн нөөцөд үзүүлэх нөлөөлөл										
Газрын хэвлийн нөөц баялаг	x				x		x		x	
Бэлчээрийн, гэжээлийн байдал	x		x	x		x				x
Эрдэс түүхий эдийн нөөц	x				x		x			x
Эрчим хүчний нөөц					x					x
Байгаль орчны нөлөөлөл										
Ундны усны чанар, хэмжээ	x		x		x					x
Агаарын бохирдол	x			x				x		
Хөрсний элэгдэл, эвдрэл	x			x			x	x		
Хог хаягдлаас үйдэлтэй бохирдол, доройтол	x			x		x			x	
Дуу чимээ, шуугианы нөлөө	x			x					x	
Нийгэмд үзүүлэх нөлөө										
Дэд бүтцийн хөгжилд нөлөөлөх	x				x		x		x	
Хүн амын орлого өөрчлөгдөж нэмэгдэх	x				x		x		x	
Ажилтай иргэдийн тоо нэмэгдэх	x				x					x
Эдийн засагт үзүүлэх нөлөөлөл										
Татварын орлого өөрчлөгдөх	x				x				x	
Орон нутгийн орлого нэмэгдэх	x				x		x		x	
Ядуурлыг бууруулахад дэмжлэг болох	x			x					x	
Ажлын байр нэмэгдэх	x				x					x
